**ГАРЧИГ**

***НЭГ. 2024 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..2***
***ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....3***
***ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....4***
***ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....16***
***ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....20***
***ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....20***
***ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....20***
***НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....23***
***ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ....31***
***АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....45***
***АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....49***
***ДҮГНЭЛТ....49***

## НЭГ. 2024 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

***Төслийн нэр:*** “Хар бичигт-1” нэртэй хайлуур жоншны ордыг ил ба далд аргаар ашиглах төсөл

***Төсөл хэрэгжүүлэгч:*** “ЧАНДМАНЬ ПЛАТИНУМ” ХХК. Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, 75б- 87 тоот.

### Төсөл хэрэгжүүлэхталбайн байршил:

***Төсөл хэрэгжүүлэгчбайгууллагын хууль эрхзүйн хүчинтэй баримтуудын жагсаалт:***

Хар бичигт-1 хайлуур жоншны орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Хэнтий аймгийн Галшар сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 460 км, Хэнтий аймгийн төв Чингис хотоос урагш 130 км, Галшар сумаас хойш 35 км зайдтус тус байрлана.

Талбайн солбицлууд:

1. 110° 58' 15.87" 46° 32' 37.77"
2. 110° 58' 3.54" 46° 32' 36.02"
3. 110° 57' 49.53" 46° 32' 36.22"
4. 110° 57' 29.13" 46° 32' 37.02"
5. 110° 57' 29.13" 46° 31' 40"
6. 110° 58' 15.87" 46° 31' 40"
7. 110° 58' 15.87" 46° 32' 1.69"
8. 110° 57' 48.49" 46° 32' 1.69"
9. 110° 57' 48.49" 46° 32' 18.72"
10. 110° 58' 15.87" 46° 32' 18.72"

Улсын бүртгэлийн гэрчилгээ

- ✓ Улсын бүртгэлийн дугаар: 9011686090
- ✓ Регистрийн дугаар: 6207251
- ✓ Улсад бүртгүүлсэн: 2017.07.27

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл

- ✓ Дугаар: MV-021543

2024 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 10 мян.м$^3$ хөрс хуулж, 2 мян.тн хайлуур жонш олборлосон болно.

# ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Болзошгүй сөрөг нөлөөллүүд | Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Хугацаа ба давтамж | Зардал, мян.төг | Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|---|---|
| **Агаар орчин** | | | | |
| **Уурхай орчимд тоосжилт үүсэх** | Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах | Үйл ажиллагааны турш | Үйл ажиллагааны зардлаас | Уурхайн ажил 2024 оны 4-р улиралд эхэлсэн бөгөөд зөвхөн бэлтгэл ажил хийсэн бөгөөд шаардлагатай хэсгүүдэд тэмдэг тэмдэглэгээ байршуулж карьер болон тээврийн гол замыг байгуулсан. |
| | Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх | Жилд 2 удаа | ОХШХ-ийн зардлаас | ОХШХ-ийн дагуу хяналт шинжилгээг 2024 оны 4-р улиралд нэг удаа хийлгэсэн. |
| **Гадаргын ба газрын доорхи усны нөөц** | | | | |
| **Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх** | Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах | Үйл ажиллагааны турш | Үйл ажиллагааны зардлаас | 2024 онд усын дүгнэлт гаргуулахаар хүсэлт өгсөн. |
| | Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх | Үйл ажиллагааны турш | Үйл ажиллагааны зардлаас | |
| | Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх | Улиралд 1 удаа | Үйл ажиллагааны зардлаас | ОХШХ-ийн хүрээнд шинжилгээ хийлгэсэн. |
| **Газрын гадарга, хэвлий** | | | | |
| **Хайлуур жонш олборлосоноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.** | Уурхайн малталтууд болон олборлосон орон зайд бэхэлгээ, хамгаалалтын цул зэргийг үлдээж нуралт үүсэхээс сэргийлнэ | Уурхай ашиглалтын төгсгөлд | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар | Энэ онд нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно. |
| **Хөрсөн бүрхэвч** | | | | |
| **Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.** | Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах, | Ашиглалтын явцад | Үйл ажиллагааны зардлаас | Ил уурхай болон хөрсний овоолгуудын талбайд өртөх нийт 4873м3 шимт хөрсийг хуулж 2437 м2 талбайд 2 метрийн өндөртэйгөөр шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан. Энэ онд нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно. |
| | Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах | | | |
| **Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох** | Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх | Ашиглалтын явцад | - | Уурхайн ажил 2024 оны 4-р улиралд эхэлж зөвхөн бэлтгэл ажил хийсэн. Уурхайн замыг байгуулсан. Бороо хур ихтэй жил байсан тул усалгаа хийгдээгүй. |

| **Ургамлан нөмрөг** | | | | |
|---|---|---|---|---|
| | Уурхайн тосгон орчимд ногоон байгууламж бий болгох | 2024 оны 10-р сард | БОМТ-ний зардлаас | Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 100ш улиас модыг уурхайн тосгон орчимд тариулсан. |
| **Амьтны аймаг** | | | | |
| **Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх** | Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах | Ашиглалтын явцад | Үйл ажиллагааны зардлаас | 2024 онд тээвэрлэлтийн ажил хийгээгүй зөвхөн бэлтгэл ажил хийсэн тул уг ажлыг 2025 онд хийхээр болсон. |



***Зураг 1. Шимт хөрсний овоолго***



***Зураг 2. Шимт хөрсний овоолго***



***Зураг 3. Шимт хөрсний овоолго***



*Зураг 4. Шимт хөрсний овоолго*



*Зураг 5. Тэмдэг тэмдэглэгээ*




***Зураг 6. Тэмдэг тэмдэглэгээ***




***Зураг 7. Тэмдэг тэмдэглэгээ***




***Зураг 8. Тэмдэг тэмдэглэгээ***




*Зураг 9. Тэмдэг тэмдэглэгээ*




*Зураг 10. Тэмдэг тэмдэглэгээ*

БАТЛАВ:
Гүйцэтгэх захирал:

БАТЛАВ: “УСТЫН УЛИАС” ХХК-ийн
Захирал: /Н. ГАНСҮХ/

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

202 оны сарын -ний өдөр № Улаанбаатар хот

Энэхүү АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ /цаашид “Гэрээ”гэх/-г,

Нэг талаас Улаанбаатар хот, Улиас Таваг Устын Улиас тоотод байрлах, И. Ганзориг түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал (цаашид **“Захиалагч”** гэх),

Нөгөө талаас “Устын улиас” ХХК (Улсын бүртгэлийн дугаар: 9011152019, РД: 5224373)-ийг төлөөлж Захирал Н. Гансүх (цаашид **“Гүйцэтгэгч”** гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх)

Монгол Улсын Иргэний хуулийн 343-358-р зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцлөөр харилцан тохиролцсоны үндсэн дээр *харилцан тохиролцож* байгуулав.

**Нэг. Нэр томъёоны тайлбар**

1.1 **“Гүйцэтгэх ажил”** гэдэг нь 100ш улиас тарих хэлнэ.

1.2 **“Ажил хийж гүйцэтгэх хугацаа”** гэдэг нь 202 оны .... дугаар сарын ....-ны өдрөөс хуанлийн .... хоногийн хугацаанд 202 оны .... дугаар сарын ....-ны өдөр хүртэлх хугацаанд гэрээнд заасан ажлуудыг бүрэн гүйцэтгэжүлсын комисст шалгуулан ажлаа хүлээлгэн өгөх хугацааг хэлнэ.

1.3 **“Гүйцэтгэсэн ажлын баталгаа”** гэдэг нь гүйцэтгэгч өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлд гаргах баталгаа бөгөөд энэхүү баталгаанд “ашиглалтын буруугаас үүдэлтэй механик гэмтэл, хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй эвдрэл гэмтэл” хамаарахгүй. Бүх тарьсан суулгацыг ургуулж хүлээлгэн өгөх үүргийг хүлээнэ, ургаагүй суулгацыг сольж өгнө

1.4 **“Давагдашгүй хүчин зүйл”** гэдэгт

- үгүй
-
-
- байгалийн гамшиг, дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, гоц халдварт өвчин тархах, түүний улмаас бүх нийтийн буюу хэсэгчилсэн хөл хорио тогтоох;
- төрийн захиргааны байгууллагын шийдвэр, экспорт, импортын хориг, эрчим хүч, ус дулаан цахилгаан хангамжийн байгууллагуудын нийлүүлэлт саатах;

1

Scanned with CamScanner

## Зургаа. Талуудын хариуцлага

6.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүйгээс нөгөө талдаа учруулсан хохирлыг гэм буруутай тал нь бүрэн хариуцна.

6.2 Талууд үндэслэлгүйгээр гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байхыг хориглоно.

6.3 Гүйцэтгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүй, ажлаа дуусгалгүй гэрээт ажлыг орхин явж, гэрээний үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээг цуцлаж, гүйцэтгэгчид төлөгдөөгүй байгаа төлбөрийг олгохгүй бөгөөд дутуу орхисон ажлыг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэн дуусгахтай холбогдон гарсан бүхий л зардал болон хохирлыг бүрэн хариуцаж төлнө.

6.4 Торгууль, алданги төлсөн нь гэрээний үндсэн үүрэг болон хариуцлагаас чөлөөлөгдөх, учирсан хохирлыг нөхөн төлөх үүргээсчөлөөлөхгүй.

## Долоо. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах болон гэрээ дуусгавар болох

7.1 Ажил гүйцэтгэх явцад гэрээнд тусгагдаагүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлторуулна.

7.2 Гэрээний аль нэг тал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах тухай үндэслэл бүхий саналаа бичгээр мэдэгдэх бөгөөд нөгөө тал нь мэдэгдлийг хүлээн аваад ажлын 3 (гурван) хоногийн дотор хариу ирүүлнэ. Хэрэв заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол гаргасан саналыг зөвшөөрсөнд тооцно.

7.3 Гэрээнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж, талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөрболно.

7.4 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал дээр нэгдэж чадаагүй тохиолдолд санал гаргасан тал нь гэрээнээс татгалзах хүртэл арга хэмжээ авч болно. Гэхдээ гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал нь гэрээний үндсэн нөхцөл, талуудын эрх, хууль ёсны эрх ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх агуулгатай байж үлболно.

7.5 Энэхүү гэрээний хавсралтуудыг талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар харилцан зөвшилцөж баталсан бөгөөд гэрээний үндсэн заалтуудын нэгэн адил хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна. Аль нэг хавсралт хүчин төгөлдөр болоогүй явдал нь энэхүү гэрээний хүчин төгөлдөр байдалд бүхэлд ньнөлөөлөхгүй.

7.6 Энэхүү гэрээ нь дараахь тохиолдолд дуусгавар болно.Үүнд:
7.6.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэснээр;
7.6.2 Талууд харилцан тохиролцсоноор
7.6.3 Хууль буюу гэрээнд заасан үндэслэлээр аль нэг тал гэрээг цуцалсан тохиолдолд.

7.7 Талууд гэрээний харилцаанд итгэлцлийг хамгаалах, туушгай байх зарчмыг баримтлах бөгөөд ялимгүй зөрчилд үндэслэж гэрээг цуцлахыг хориглоно.

7.8 Гэрээний аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн нь гэрээг цуцлах үндэслэлболно.

7.9 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн болон Иргэний хуульд заасан бусад үндэслэлээр энэхүү гэрээг цуцлах тохиолдолд гэрээг цуцлах тухай мэдэгдлийг ажлын 5 хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр хүргүүлнэ. Ийнхүү мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 5 хоног өнгөрмөгц гэрээ дуусгавар болсон гэжүзнэ.

7.10 Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, гэрээг цаашид хэрэгжүүлэх

Scanned with CamScanner

боломжгүй болсныг үндэслэн нөгөө тал нь шүүхэд нэхэмжлэл гаргах замаар буюу шүүхийн шийдвэрээр энэхүү гэрээг цуцалжболно.

**Найм. Маргаан шийдвэрлэх**

8.1 Энэхүү гэрээнээс үүдэлтэй болон гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Үндэсний Арбитрт түүний Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрмийн дагуу Монгол улсад эцэслэн шийдвэрлэнэ.

**Ес. Давагдашгүй хүчин зүйл**

9.1 Гэрээний аль нэг тал гэрээний 1.4-т заасан давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол гэрээнд заасан гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

9.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл ажлын 5 хоногоос дээш хугацаагаар үргэлжлэх бол талууд харилцан тохиролцож, энэхүү гэрээнд заасан үүрэг гүйцэтгэх хугацаанд өөрчлөлт оруулжболно.

9.3 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртсөн тал нь тухайн нөхцөл байдал болон, угхүчин зүйл дууссан талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэхүүрэгтэй.

**Арав. Бусад зүйл**

10.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

10.2 Энэхүү гэрээг 2 /хоёр/ хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.

10.3 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ нөгөө талын бичгэн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй.

10.4 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй боловч гэрээтэй холбоотой үүсэн гарах аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| Захиалагчийг төлөөлж: | Гүйцэтгэгчийг төлөөлж: |
|---|---|
| ______________________ | ______________________ |
| Албан тушаал: | Нэр: Н. Гансүх |
| ______________________ | Албан тушаал: Захирал |
| Нэр: | Утас: 99685072 |
| Албан тушаал: | |
| Утас: | |
| Хаяг: | Хаяг: ЧД, 14-р хороо, Хайлааст, 20-631 |

УЛААНБААТАР ХОТ
УСТЫН УЛИАС ХХК

Scanned with CamScanner

*Зураг 111. "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажил гүйцэтгүүлсэн гэрээ*




***Зураг 12. Мод тарих ажлын төлбөр төлсөн баримт***





***Зураг 13. Мод тарих явц***







*Зураг 14. Мод тарих явц*

## ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Хар бичигт-1” хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хувьд уул техникийн нөхцлөөс шалтгаалан нөхөн сэргээлт хийгдэх боломжгүй учир 2024 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно.

## ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд 2024 онд Хэнтий аймгийн Галшар сум 2 дугаар багийн нутаг дэвсгэр Бичигтийн рашаан нэртэй булгийг ЧАНДМАНЬ ПЛАТИНИУМ ХХК-д хувиарлан өгсөн ба булгийг үйлдвэрийн торон хашаагаар хашаалж, тэмдэг тэмдэглэгээ суурьлуулан нөхөн сэргээлт хийж гүйцэтгэлээ.



***Зураг 15. Дүйцүүлэн хамгаалах ажлын өмнө***



***Зураг 126. Дүйцүүлэн хамгаалах ажлын өмнө***



*Зураг 17. Дүйцүүлэн хамгаалах ажлын дараа*



*Зураг 18. Дүйцүүлэн хамгаалах ажлын дараа*



*Зураг 19. Дүйцүүлэн хамгаалах ажлын дараа*



***Зураг 20. Дүйцүүлэн хамгаалах ажлын дараа***



ХЭНТИЙ АЙМГИЙН
ГАЛШАР СУМЫН ЗАСАГ
ДАРГА

Буянтбулаг баг, Галшар сум
Хэнтий аймаг, 23080, Утас: 98141950
Цахим шуудан: zdtg_galshar@yahoo.com

2024.10.25 № 1/65
танай ______ -ны № ______ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ

Чандмань платиниум ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд манай суманд малчдад зориулсан гүний худаг гаргах хүсэлт гаргасан бөгөөд 2024 оны газар төлөвлөлтөнд багтаагүй тул 2025 онд төлөвлөлтөнд оруулж худаг гаргахаар болсон нь үнэн болно.

Д.НЯМБААТАР

***Зураг 21. Дүйцүүлэн хамгаалах ажлын усалгаанд зориулсан худгийн тухай***

## ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг уурхай хаагдах үед хаалтын зардалд тусгаж өгсөн тул 2024 оны БОМТ-нд энэ чиглэлийн үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй болно.

## ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“ЧАНДМАНЬ ПЛАТИНИУМ” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна.

## ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Зардал | Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гал түймэр | Галын булан байрлуулах | Уурхайн тосгон | Ашиглалтын зардлаас | Уурхайд галын булан байрлуулсан |
| | | Аваар устгах төлөвлөгөө боловсруулах | Уурхай | | Аваар устгах төлөвлөгөө боловсруулан батлуулж, мөрдлөг болгон ажилласан. |
| 2 | Тэсрэх бодис | Мэргэжлийн гэрээт байгууллагаар тэсэлгээний ажил гүйцэтгүүлэх | Тэсэлгээний ажлын үед | | Өрөмдлөг тэсэлгээний ажлыг гэрээт компаниар гүйцэтгүүлэн аюул ослоос урьдчилан сэргийлж ажилласан. Түүнчлэн тэсрэх бодисын сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанид хүлээлгэн өгсөн. |
| | | Тэсрэх бодисын тоо бүртгэлийг тогтмол хийх | | | |
| | | Тэсрэх бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан аюулгүй болгох | | | |



*Зураг 22. Уурхайн талбай дахь галын булан*

**БАТЛАВ:**
"ЧАНДМАНЬ ПЛАТИНИУМ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ WANG ZHENFA

2024 оны 08 сарын 16 өдөр

**ЗӨВШӨӨРСӨН:**
УУЛ УУРХАЙН АВРАХ 09 ДҮГЭЭР АНГИЙН ЗАХИРАГЧ ХУРАНДАА Д.ГАНТУЛГА

2024 оны 08 сарын 16 өдөр

# ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ХАР БИЧИГТ-1 НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2024 ОНЫ АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндсэн АТЗ-ын дугаар: MV-021543

**ХЯНАСАН:**
УУЛ УУРХАЙН АВРАХ АНГИЙН АЛБАНЫ ДАРГА, АВРАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДАГЧ, ХОШУУЧ Д.БАЯРЖАРГАЛ

**БОЛОВСРУУЛСАН:**
"ЧАНДМАНЬ ПЛАТИНИУМ" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР YANGFENGJUN

**2024 он**

*Зураг 23. 2024 оны батлагдсан аваарь устгах төлөвлөгөө*

## НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Болзошгүй сөрөг нөлөөлөл | Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Зардал, мян.төг | Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|---|
| Хог хаягдлын цэг, ангилан ялгах үйлдвэрийн талбай, кемп орчимд бохирдол үүсгэж болзошгүй | Хог хаягдлыг ялгах, зайлуулах, устгах, цэвэршүүлэх менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах | **1 115.0** | Хог хаягдлыг нэгдсэн цэгт төвлөрүүлж, хог хаягдлын гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлж байсан. |
| Нийт | | **1 000.0** | |

Хог хаягдлын гэрээг Хэнтий аймгийн Галшар сумынзасаг даргатай байгуулсан. Мөн Аюултай хог хаягдал боловсруулах, зайлуулах гэрээг уг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөлтэй Элемент ХХК-тай гэрээ байгуулан ажилласан. /Хог хаягдлын гэрээ, санхүүгийн баримтыг хавсаргав./

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

**ТӨЛБӨРИЙН БАРИМТ**

ДДТД: 000002100061000241030000001154152
**Борлуулагчийн:**
ТТД: 2100061
НЭР: Элемент
Хаяг: Улаанбаатар, Налайх, 3-р хороо, null
Утас: 86113790
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2024-10-30
**Худалдан авагчийн:**
ТТД: 6207251
Нэр: Чандмань платиниум
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянзүрх, 18-р хороо, , 87 тоот
Утас:

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Аюултай хог, хаягдал боловсруулах, зайлуулах үйлчилгээ | 5 | ш | 1 | 2,500,000 | 2,500,000 |

| | |
|---|---|
| Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 2,272,727.27 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 227,272.73 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 2,500,000 |

Хүлээн авсан: ........................................................ /....................................../
*(гарын үсэг) (нэр)*

Хүлээлгэн өгсөн: ................................................ /....................................../
*(гарын үсэг) (нэр)*

***Зураг 24. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт***

БАТЛАВ:
ГАЛШАР СУМЫН
ЗАСАГ ДАРГА..............Д.НЯМБААТАР

БАТЛАВ:
ЧАНДМАНЬ ПЛАТИНИУМ ХХК-ны
ЗАХИРАЛ.............WANG ZHEN FA

**ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ**

2024 оны 07 дугаар сарын 03-ний өдөр    № 03    Галшар сум

**Нэг: Нийтлэг үндэслэл**

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 9.2, 10.1, 10.2, 20.1, 20.2 дугаар зүйлийг тус тус үндэслэв.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх, булулгах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр, эрүүл орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бий болгоход оршино.

**Хоёр: Гэрээ байгуулагч талууд**

Нэг талаас Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрыг төлөөлж Байгаль хамгаалагч С.Тогоохүү, Нөгөө талаас " Чандмань платиниум" ХХК-ны Захирал WANG ZHEN FA нар харилцан тохиролцож 2024 оны 07 дугаар сарын 03-ний өдрөөс 2024 оны 11 дугаар сарын 25-ний өдөр хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

**Гурав: Төлбөр тооцсон байдал**

Хэнтий аймгийн Галшар сумын ИТХ-ын 2011 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 17 тоот тогтоолоор батлагдсан журмын дагуу төлнө.    Ажиллах хугацаа 5 сар

Сарын төлбөр 223000 / Хоёр зуун хорин гурван мянга /

Жилийн нийт төлбөр мянга / Нэг сая нэг зуун арван таван мянган /төгрөг.

**Дөрөв: Сумын ЗДТГ-ын эрх**

1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах.
2. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх.
3. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих.
4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэд хяналт тавих.

**Тав: Иргэн Аж ахуйн нэгж байгууллагын эрх үүрэг**

Scanned with CamScanner

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.
2. Хог хаягдлыг ангилан ялгаж байх.
3. Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлж, сургалт, сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах
4. Үйлдвэр, үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх.
5. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтоосон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаарх дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.
6. Нийгмийн хариуцлагын хүрээнд Сангийндалай багийн төвийн засвар үйлчилгээ, гадна тохижилтод санхүүгийн болон эд материалын дэмжлэг туслалцаа үзүүлэх.
7. Уурхай орчимын болон Бичигт,Гашууны гол дагуу үхсэн мал, амьтны сэг зэмийг цэвэрлэж, булшлах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажилд туслалцаа дэмжлэг үзүүлэх.
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын талаарх хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах.
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх.
10. Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор гэрээнд зааснаар Төрийн сан банкны 180100947 тоот дансанд тогтмол шилжүүлж байна.

**Зургаа: Гэрээний хариуцлага**

1. Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал гаргасан төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлага барагдуулах ба учруулсан хохирлыг арилгах, шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандаж Хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.
2. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

**Гэрээ байгуулсан:**

" ЧАНДМАНЬ ПЛАТИНИУМ" ХХК-НИЙ ЗАХИРАЛ WANG ZHEN FA

Утас: 88987258

ГАЛШАР СУМЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ С.ТОГООХ

Утас: 89938331

Scanned with CamScanner

*Зураг 25. Хог хаягдлыг тээвэрлэх гэрээ*

**БАТЛАВ:**
**"ЭЛЕМЕНТ" ХХК-ИЙН**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**
**Б.ЭНХБАДРАЛ**

**БАТЛАВ:**
**"ЧАНДМАНЬ ПЛАТИНИУМ" ХХК-ИЙН**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**
**Wang Zhenfa**

**ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

№ ХБ-24/159

2024 оны 10 -р сарын 21-ны өдөр Улаанбаатар хот

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1. Нэг талаас "Элемент" ХХК РД: /2100061/ /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ түүнийг төлөөлж, Химийн мэргэжилтэн албан тушаалтай Э.Намжилсүрэн, нөгөө талаас /цаашид "Захиалагч" гэх/-ыг "Чандмань платиниум"ХХК РД:/ 6207251 / түүнийг төлөөлж Инженер албан тушаалтай Ч. Оч-Ертөнц нар харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд химийн аюултай хог хаягдлыг зориулалтын газарлуу ачиж тээвэрлэх, зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг устгах, захиалагч төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

1.2. Дараах баримт бичиг гэрээний салшгүй хэсэг болно.

1.2.1 Аюултай хог хаягдалтай харьцан ажиллаж буй ажилтны мэргэжилийн үнэмлэх, /хүчинтэй хугацаа, цээж зураг, тамга тэмдэг дарагдсаныг тулгах/

1.2.2 Химийн хортой аюултай бодисын хаягдлыг тээвэрлэх, ачих, буулгах, зөөвөрлөх үеийн эрсдэлийн үнэлгээг хийх /Гүйцэтгэгч компанийн Гүйцэтгэх захирлын гарын үсэг, тамга, Ерөнхий болон тус ажлыг хариуцсан инженерүүд, ажилчдын гарын үсгээр баталгаажсан эх хувь

**ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ**

2.1. Захиалагч дараах эртэй:

2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,

2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.

2.2. Захиалагч дараах үүрэгтэй:

2.2.1. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь "Аюултай хог хаягдал" гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх,

2.2.2. Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах,

2.2.3. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах,

2.2.4. Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах,

2.2.5. Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих,

2.2.6. Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх,

2.2.7. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг захиалагч бүрэн хариуцлага хүлээх,

2.2.8. Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтаныг байгууллага дээрээ байлгаж, хог ачилтанд хяналт тавих тус тус үүрэгтэй.

### ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:

3.1.1. Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

3.1.2. Аюултай хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй,

3.1.3. Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, аюултай тэмдэглэгээтэй байхыг шаардах хаяггүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй,

3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй

3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Аюултай хог хаягдлыг ачиж тээвэрлэх, тээврийн хэрэгслийг ажилд бэлэн байлгаж, захиалагч талын хог хаягдлыг гэрээнд заасан хуваарийн дагуу хугацаанд зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх,

3.2.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгсэлийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,

3.2.3. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,

3.2.4. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,

3.2.5. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах

3.2.6. Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй,

3.2.7. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

## ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

4.1. Үйлчилгээний төлбөр нь тухайн устгах аргачлалын дагуу устгалын үед аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх бүрт тооцож нэхэмжилнэ. Аюултай хог хаягдлын устгалын төлбөрийг хавсралт №1-т тусгав.

4.2. Энэхүү гэрээ 2024 оны 10 -р сарын 21 -ны өдрөөс 2025 оны 10-р сарын 21-ны өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд талууд гэрээний хугацаа өнгөрмөгц дуусгавар болгох талаар санал гаргаагүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

4.3. Захиалагч аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулахдаа гэрээний баталгаа болгож **2'500'000.0 / Хоёр сая таван зуун мянга/** төгрөгийг 4.5 дахь заалтанд заасан дансанд байршуулна. Урьдчилгаа төлбөр нь гэрээний хүчинтэй хугацаанд хийгдсэн тээвэрлэлт, устгалын зардлаас хасагдаж тооцогдоно.

4.4. Аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч ачилт тээвэрлэлт хийх үед болон устгалын төвд хүлээн аван нарийн хэмжилт хийх үед гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд гүйцэтгэлээр захиалагч талаас нэхэмжлэнэ.

4.5. Гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссаны дараа гэрээнд заасан журмаар гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор "Элемент" ХХК-ийн **1715164140 /Голомт банк/** тоот дансанд төлнө.

4.6. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаандаа төлбөр төлөгдөөгүй тохиолдолд боломжит хугацааг мэдэгдэж, онцгой обьектыг харгалзан үзэж, энэхүү хугацаанд төлбөр төлөх хүртэл үйлчилгээг тасалдуулахгүй хүргэнэ,

4.7. Төлбөр тооцоог байгууллагын данснаас бусад хувь хүний дансанд шилжүүлсэнээс үүдэх хохиролыг гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.

4.8. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

## ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Талууд гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэм буруутай тал нөгөө талдаа учирсан хохирлыг төлнө.

5.2 Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг Гүйцэтгэгч тал хангаж ажиллах бөгөөд ХАБЭА-н зааварчилгааны дагуу ажиллах үүрэгтэй.

5.3 Захиалагч талын байгууллагын бүсэд нэвтэрсэн тохиолдолд захиалагч талаас тавьсан ХАБЭА-н шаардлагыг гүйцэтгэгч тал хангаж ажиллах бөгөөд Элемент ХХК-ийн тээврийн хэрэгслийг давуу эрхийн дагуу хөдөлгөөнд оролцуулна.

5.4 Захиалагч тал гүйцэтгэгч талын ажлаа явуулах боломжоор байгууллагын хүрээнд хангаж өгөх үүрэг хүлээнэ.

5.5 Талууд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 12 дугаар болон бусад холбогдох зүйлд заасан шаардлагыг хангаж хамтран ажиллах үүрэгтэй.

## ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө

